



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ  
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

**Албан тушаалын үндсэн цалинг  
нэмэгдүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын нийт ажилтнуудын үндсэн цалингийн жишигтэй уялдуулан Баруун, Зүүн салбарын Нийтэд үйлчлэх хэсгийн Нийтийн бие засах газрын үйлчлэгч нарын сарын үндсэн цалинг 507 000 /Таван долоон мянган/ төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.

2. Дээрх цалингийн өөрчлөлтийг 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн мөрдөж, цалин хөлсийг бодож олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /Б.Мөнх-Оргил/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Б.ГАНЗОРИГ

